



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/871

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Байгаль эх, хариуцлагатай уул уурхай” үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулах зардалд 534 000 төгрөг, Засаг дарга хотод ажилласан зардалд 344 000 төгрөг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр биелэлтийн талаарх салбар хороодын хэлэлцүүлэг зохион байгуулсан зардалд 1 559 000 төгрөг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 437 000 төгрөг /Хоёр сая дөрвөн зуун гучин долоон мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ



03\_04293  
D/Zax-A/871-Da